



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/21/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Э.Нандинчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗТХС	Зам Тээвэр Хөгжлийн Сайд
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**Агуулга**

Аудитын гэрчилгээ .....	1
Аудитын тайлан.....	3
2.1. Оршил .....	3
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	3
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	4
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	4
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	5
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	6
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	8
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	8
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	9
3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	12
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13

  
**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 186

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баянтүмэн сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Баянтүмэн сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520110



### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



## **2.1. Оршил**

Баянтүмэн сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч О.Зина танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

## **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтүмэн сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтүмэн сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянтүмэн сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан



үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Баянтүмэн сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд нэг бүрийг ажилсаг, эвсэг амьдралын зөв дадалтай болгон хөгжүүлэх”-д оршино.

Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Үүнд:

- Цэцэрлэгийн үйл ажиллагааг хамтын оролцоотойгоор үнэлж, үр дүнг үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх.
- Багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх, сургуулийн өмнөх насныханд зөв суурийг тавих.
- Хичээл сургалтын үйл ажиллагаанд заах аргын нэгдэл багаар хамтран чанартай бэлтгэх ээлжит хичээлийг хүүхдийн ялгаатай байдал хэрэгцээ сонирхол харгалзан адил тэгш оролцоог хангах үр өгөөжтэй зохион байгуулах чиглэлээр багшийн заах арга ур чадварыг хөгжүүлэх.

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянтүмэн сумын цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Баянтүмэн сумын цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Баянтүмэн сумын Цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 224,407.4 мянган төгрөгөөс тооцон 4,488.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянтүмэн сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,186.21 мянган төгрөгөөр буюу 5,09 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	5,707.25	5,422.25	(285.00)
Урьдчилгаа			-
Бараа материал	13,976.51	20,204.63	6,228.12
Үндсэн хөрөнгө	106,691.10	114,751.51	8,060.41
Хуримтлагдсан элэгдэл	(29,867.86)	(38,685.18)	(8,817.32)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>96,507.00</b>	<b>101,693.21</b>	<b>5,186.21</b>
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	96,507.00	101,693.21	5,186.21
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>96,507.00</b>	<b>101,693.21</b>	<b>5,186.21</b>

Бараа материалын дансны үлдэгдэлд тусгай зориулалтын материал 2,248.0 мянга, бичиг хэргийн 598.1 мянга, аж ахуйн 15,649.5 мянга, барилгын материал 1,209.0 мянга, бусад хангамжийн материал 499.9 мянган төгрөг тус тус байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 3,320.0 мян төгрөгөөр Гал тогооны тоног төхөөрөмж болон Компьютер принтер, 4,740.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 101,693.2 мянган төгрөг болж 5,186.2 мянган төгрөгөөр өссөн нь бараа материал, үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 218,228.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 199,428.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 18,800.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 218,009.7 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

## 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэл тогтоож 31 эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 34,273.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 33,953.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 320.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 төлбөрийн акт өглөө. Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Аудитаар дараах 34,273.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг жишиг нормоор тооцоолоход 1,075.3 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтанд заагдсан “автомашинны 100км-т зарцуулах жишиг норм” гэсэн тушаалд нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд гарсан зардлаас 28,986.4 мянган төгрөгийн зардлыг ибаримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Бараа материалыг эхний болон эцсийн үлдэгдэлд нэр төрөл, үнийн дүнг тусгаагүй багцаар нь бүртгэсэн 3,891.4 мянган төгрөг байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь хэгийн “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн



41.2.3.дэх “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” заалтыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.  
мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Хүнсний материал нийлүүлэх гэрээний үнэ болон бодит худалдан авалтын үнийн зөрүү 320.4 мянган төгрөг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41.1.2-т заасан гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх тухай заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар илэрсэн 2,031.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

- ✓ Бараа материалын орлогыг бүртгэлд тусгахдаа нэр төрөл бүрээр ангилж бүртгэх.
- ✓ Худалдан авалтын гэрээний нэгжийн үнэ, түүний өөрчлөлтийг нягтлан шалгах.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Баянтүмэн сумын Цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 138 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянтүмэн сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянтүмэн сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

**Аудит хийгдсэн санхүүгийн тайлан**

**3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,683,758.26</b>	<b>25,626,880.88</b>
33	<b>АВЛАГА</b>	5,707,252.00	5,422,252.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,707,252.00	5,422,252.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	13,976,506.26	20,204,628.88
351	<b>Түүхий эд материал</b>	2,248,030.00	2,248,030.00
35110	Тусгай зориулалттай материал	2,248,030.00	2,248,030.00
354	<b>Хангамжийн материал</b>	11,728,476.26	17,956,598.88
35410	Бичиг хэргийн материал	169,050.00	598,150.00
35420	Аж ахуйн материал	10,349,116.00	15,649,538.88
35440	Түлш, шатах тослох материал	0.86	-
35450	Барилгын засварын материал	1,209,000.00	1,209,000.00
35460	Хүнсний материал	1,309.40	-
35470	Бусад хангамжийн материал	-	499,910.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>76,823,245.37</b>	<b>76,066,328.71</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	76,823,245.37	76,066,328.71
392	<b>Биет хөрөнгө</b>	68,945,245.37	68,188,328.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	45,480,573.34	45,480,573.34
39202	Хуримлагдсан элэгдэл	-	(2,946,303.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	23,652,680.00	26,972,680.00
39206	Хуримлагдсан элэгдэл	(15,428,774.43)	(18,483,425.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,796,091.00	30,536,499.12
39208	Хуримлагдсан элэгдэл	(13,793,574.54)	(16,351,740.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,881,560.00	2,881,560.00
39215	Хуримлагдсан элэгдэл	(645,510.00)	(903,714.00)
39217	Ном	1,002,200.00	1,002,200.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	7,878,000.00	7,878,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,878,000.00	7,878,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>96,507,003.63</b>	<b>101,693,209.59</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	0.00
413	<b>Өглөг</b>	0.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>96,507,003.63</b>	<b>101,693,209.59</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	96,507,003.63	101,693,209.59
511	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	34,082,720.60	34,082,720.60
51101	Өмч: - төрийн	34,082,720.60	34,082,720.60
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	25,056,952.06	30,243,158.02
51210	Өмнөх үеийн үр дүн	25,056,952.06	25,056,952.06
51220	Тайлант үеийн үр дүн	-	5,186,205.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	37,367,330.97	37,367,330.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V</b>	<b>96,507,003.63</b>	<b>101,693,209.59</b>

### 3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>196,276,000.00</b>	<b>229,593,631.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,636,000.00</b>	<b>10,666,631.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>7,636,000.00</b>	<b>10,666,631.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,636,000.00	10,666,631.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,636,000.00	10,666,631.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>188,640,000.00</b>	<b>218,927,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>187,465,200.00</b>	<b>199,428,000.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	187,465,200.00	199,428,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,174,800.00</b>	<b>699,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээлээс авсан хандив, тусламж	-	599,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,174,800.00	100,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>18,800,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	18,800,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>196,864,087.44</b>	<b>224,407,425.04</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>196,864,087.44</b>	<b>224,407,425.04</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>178,063,444.44</b>	<b>224,199,662.85</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>111,057,167.00</b>	<b>139,376,642.01</b>
210101	Үндсэн цалин	89,767,427.00	107,870,369.01
210102	Нэмэгдэл	12,341,784.00	17,527,600.00
210104	Урамшуулал	8,947,956.00	13,978,673.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,849,405.33</b>	<b>17,398,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,623,816.33	11,966,669.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,028,258.00	1,407,714.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	836,450.00	1,126,332.00
210204	Ажилгүйдлийн даатгал	248,136.00	671,935.00
210205	Эрүүд мэндийн даатгал	2,112,745.00	2,226,250.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,846,978.00</b>	<b>17,299,263.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,588,178.00	941,643.80
210302	Түлш, халаалт	7,797,700.00	12,537,620.00
210303	Цэвэр, бохир ус	461,100.00	3,820,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,865,939.14</b>	<b>5,178,932.86</b>
210401	Бичиг хэрэг	182,700.00	826,320.00
210402	Тээвэр, шатахуун	1,831,039.14	2,365,032.86
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	594,000.00
210404	Ном, хэвлэл	107,200.00	-
210406	Бага үнэтэй, гургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	745,000.00	1,393,580.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>31,841,900.00</b>	<b>32,134,809.40</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,700.00	800,000.00
210502	Хоол, хүнс	31,339,000.00	31,334,809.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	438,200.00	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>1,500,000.00</b>
210604	Урсгал засвар	-	1,500,000.00
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>148,900.00</b>	<b>627,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	148,900.00	627,700.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>180,000.00</b>	<b>898,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	718,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,273,154.97</b>	<b>9,785,414.78</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	618,300.00	968,090.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,654,854.97	8,817,324.78
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,800,643.00</b>	<b>207,762.19</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,773,800.00</b>	<b>100,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,832,900.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,940,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	100,000.00

«Audit\_name» Баянтүмэн сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	736.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	736.20
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,843.00	107,025.99
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,843.00	107,025.99
3	ҮНД АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(588,087.44)	5,186,205.96
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(588,087.44)	5,186,205.96

### 3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>188,640,000.00</b>	<b>218,927,000.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>188,640,000.00</b>	<b>218,927,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>187,465,200.00</b>	<b>199,428,000.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	187,465,200.00	199,428,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,174,800.00</b>	<b>699,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	599,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,174,800.00	100,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>18,800,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	18,800,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>188,640,000.00</b>	<b>218,927,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>188,640,000.00</b>	<b>218,927,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>169,839,357.00</b>	<b>218,719,237.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>111,007,167.00</b>	<b>139,091,642.01</b>
210101	Үндсэн цалин	90,047,311.00	107,585,369.01
210102	Нэмэгдэл	12,011,900.00	17,527,600.00
210104	Урамшуулал	8,947,956.00	13,978,673.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,323,672.00</b>	<b>17,398,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,924,372.00	11,966,669.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,099,900.00	1,407,714.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	879,800.00	1,126,332.00
210204	Ажилгүйдлийн даатгал	220,000.00	671,935.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,199,600.00	2,226,250.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,846,978.00</b>	<b>17,299,263.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,588,178.00	941,643.80
210302	Түлш, халаалт	7,797,700.00	12,537,620.00
210303	Цэвэр, бохир ус	461,100.00	3,820,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,871,140.00</b>	<b>6,551,332.00</b>
210401	Бичиг хэрэг	182,700.00	826,320.00
210402	Тээвэр, шатахуун	1,831,040.00	2,365,032.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	594,000.00
210404	Ном, хэвлэл	112,400.00	297,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	745,000.00	2,468,880.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31,843,200.00</b>	<b>33,752,400.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,700.00	800,000.00
210502	Хоол, хүнс	31,340,300.00	31,333,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	438,200.00	1,618,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>1,500,000.00</b>
210604	Урсгал засвар	-	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>148,900.00</b>	<b>627,700.00</b>
210702	Дотоод албан томилголт	148,900.00	627,700.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000.00	898,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	718,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	618,300.00	1,600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	618,300.00	1,600,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,800,643.00</b>	<b>207,762.19</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,773,800.00	100,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,832,900.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,940,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	736.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	736.20
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,843.00	107,025.99
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,843.00	107,025.99
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	34,082,720.60	37,367,330.97	25,056,952.06	-	96,507,003.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,082,720.60	37,367,330.97	25,056,952.06	-	96,507,003.63
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн					-
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,082,720.60	37,367,330.97	25,056,952.06	-	96,507,003.63
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	34,082,720.60	37,367,330.97	25,056,952.06	-	96,507,003.63
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,082,720.60	37,367,330.97	25,056,952.06	-	96,507,003.63
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			5,186,205.96		5,186,205.96
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,082,720.60	37,367,330.97	30,243,158.02	-	101,693,209.59

### 3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>218,228,000.00</b>	<b>218,120,237.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>218,228,000.00</b>	<b>218,120,237.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>218,228,000.00</b>	<b>218,120,237.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>139,194,300.00</b>	<b>139,091,642.01</b>
210101	Үндсэн цалин	106,375,500.00	107,585,369.01
210102	Нэмэгдэл	17,527,600.00	17,527,600.00
210104	Урамшуулал	15,291,200.00	13,978,673.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,398,900.00</b>	<b>17,398,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,831,500.00	11,966,669.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,373,000.00	1,407,714.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,057,800.00	1,126,332.00
210204	Ажилгүйдлийн даатгал	352,800.00	671,935.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,783,800.00	2,226,250.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,300,000.00</b>	<b>17,299,263.80</b>
210301	Гэрэл, пахилгаан	1,750,000.00	941,643.80
210302	Түлш, халаалт	11,730,000.00	12,537,620.00
210303	Цэвэр, бохир ус	3,820,000.00	3,820,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,300,800.00</b>	<b>6,300,332.00</b>
210401	Бичиг хэрэг	800,400.00	800,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,320,000.00	2,319,952.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	594,000.00	594,000.00
210404	Ном, хэвлэл	297,500.00	297,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,288,900.00	2,288,880.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>33,754,000.00</b>	<b>33,752,400.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	800,000.00	800,000.00
210502	Хоол, хүнс	31,334,000.00	31,333,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,620,000.00	1,618,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томлолт, зочны зардал</b>	<b>600,000.00</b>	<b>599,700.00</b>
210702	Дотоод албан томлолт	600,000.00	599,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>580,000.00</b>	<b>578,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00	398,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,600,000.00</b>	<b>1,600,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,600,000.00	1,600,000.00